

МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

Журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 дугаар тушаалаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын Гурав дахь заалтын 3.2-ыг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтад зааснаар өөрчлөн найруулсугай.

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А-93 дугаар тушаалаар баталсан “Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам”-д “1.6 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийг цахимаар таньж мэдэх үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ тухайн хэрэглэгчийн төрийн цахим мэдээллийн сан дахь биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр иргэний үнэмлэхийн бүртгэлийн лавлагааг, эсхүл улсын бүртгэлийн мэдээллийн сангийн иргэний үнэмлэхийн бүртгэлийн цахим лавлагааг авна” гэх агуулга бүхий 1.6 дахь заалт нэмж, мөн журмын 1 дүгээр хавсралтын 2.3-т заасан үйлчилгээний төрөлд “данс нээлгэх хүсэлт гаргах”, “төлбөрийн карт захиалах хүсэлт гаргах” гэж тус тус нэмсүгэй.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А-93 дугаар тушаалаар баталсан “Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам”-ын 1.3.17 дахь заалтын “өөрийн данс руу хандаж, төлбөр гүйцэтгэх” гэснийг “данс нээлгэх, өөрийн данс руу хандаж төлбөр гүйцэтгэх” гэж өөрчилсүгэй.

4. Энэхүү тушаалын 1 дэх заалтын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (...), 2, 3 дахь заалтын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (...), Дотоод аудитын газар (...) -т тус тус даалгасугай.

Төсөл
Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны ...
дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

“3.2. Харилцагч нь хувь хүн бол:

| Хүснэгт 1 | |
|--|--|
| Харилцагчаас авах мэдээлэл | Тулгаж шалгах бичиг баримт ¹ |
| Овог, эцэг /эх/-ийн нэр | Иргэний үнэмлэх, паспорт эсхүл иргэний үнэмлэхийн бүртгэлийн цахим лавлагаа |
| Өөрийн нэр | Иргэний үнэмлэх, паспорт эсхүл иргэний үнэмлэхийн бүртгэлийн цахим лавлагаа |
| Төрсөн огноо | Иргэний үнэмлэх, паспорт эсхүл иргэний үнэмлэхийн бүртгэлийн цахим лавлагаа |
| Регистрийн дугаар | Иргэний үнэмлэх, паспорт эсхүл иргэний үнэмлэхийн бүртгэлийн цахим лавлагаа |
| Байнгын оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар | Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна. |
| Одоо оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар | Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна. |
| Эрхэлж буй ажил, бизнес: 1. Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах 2. Ажлын газрын нэр, хаяг, албан тушаалыг тодруулах | Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна. |
| Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэхийг тодруулах | А.Хэрэв харилцагч нь хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлэгч этгээдийн мэдээллийг авна. Төлөөлүүлэгч этгээд нь хувь хүн бол Хүснэгт 1, хуулийн этгээд бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гаргуулан авч үнэн бодит эсэхийг нь тодорхойлж, мэдээллийг нь баталгаажуулах шаардлагатай. В. Хэрэв захиалагч нь хуулийн этгээд эсхүл гэрээ хэлцлийг төлөөлж байгаа бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гүйлгээ эсхүл бизнесийн харилцаанд орж буй хөрөнгийн эцсийн өмчлөгчийг тодорхой болох хүртэл гаргуулан авна. Хэрэв эцсийн өмчлөгч тогтоох |

| | |
|--|--|
| | <p>боломжгүй өмчлөлийн бүтэцтэй бол шийдвэр гаргаж байгаа, харилцагчийн үйлдлийг удирдан чиглүүлж байгаа хувь хүн тодорхой болох хүртэл гаргуулан авна.</p> <p>Харилцагчаас гаргуулан авсан мэдээллийн бодит байдлыг нотлох баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулан авч үнэн бодит байдлыг нь хянана.</p> <p>С.Хэрэв харилцагч нь Trust буюу Итгэлцлийн /хөрөнгө итгэмжлэх/ гэрээгээр бизнесийн харилцаанд орж байгаа бол дараах этгээдийн мэдээллийг харилцагчаас гаргуулан авна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1.Trust буюу Итгэлцлийн /хөрөнгө итгэмжлэх/ гэрээний “Settlor” буюу хөрөнгөө уг гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд;2.Trust буюу Итгэлцлийн /хөрөнгө итгэмжлэх/ гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/;3.Trust буюу Итгэлцлийн /хөрөнгө итгэмжлэх/ гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/;4.Хэрэв байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”-ын мэдээлэл;5.Гэрээний ашиг шимийг хүртэгч нь хуулийн этгээд хэлбэртэй байгаа тохиолдолд уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл. <p>Д.Дээрхээс өөр төрлийн гэрээ хэлцлийн хувьд дээрхтэй ижил байр суурин дээр байгаа хувь хүмүүсийг тогтоох үйл ажиллагааг хийнэ.</p> |
|--|--|